



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 35 06, Факс: (976-11) 31 81 69,
Цахим хуудас: www.mmhi.gov.mn

2023.11.23 № 03/2760
танай _____-ны № _____-т

ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БАЙГУУЛЛАГУУДАД

Хамтран ажиллах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталж, 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 болон 8.2 дахь хэсэгт “дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан барааны нэр, төрлийн жагсаалтыг эдийн засаг, хөгжлийн, хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, Засгийн газар батална” гэж заасны дагуу Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-ыг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна

Иймд танай байгууллагаас тус жагсаалтад оруулах чанар, стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны нэр, төрлийн жагсаалтыг тухайн барааны товч тодорхойлолт, итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн, хүчин төгөлдөр тохирлын гэрчилгээний хуулбарын хамт 2023 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн дотор албан бичгээр болон цахим (oyunbold@mmhi.gov.mn) хаягаар ирүүлж, хамтран ажиллахыг хүсье.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

1508 04 2030